



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 4/535

Чингис хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын "а" 29.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүх нийтийн бэлэн байдалд шилжсэнтэй холбоотойгоор иргэн хуулийн этгээдийн хандивласан бэлэн мөнгө болон эд материалын хандивыг бүртгэж авах, зарцуулах, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахаар "Цар тахал /Ковед-19/-н үед аймгийн онцгой комиссын үйл ажиллагаанд зориулж иргэн, хуулийн этгээдээс хандивласан хандивын хөрөнгийг хүлээн авах, зарцуулах, тайлагнах журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ИДЭРБАТ

**ЦАР ТАХАЛ /КОВЕД-19/-Н ҮЕД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ЗОРИУЛЖ ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭС ХАНДИВЛАСАН ХАНДИВЫН ХӨРӨНГИЙГ
ХҮЛЭЭН АВАХ, ЗАРЦУУЛАХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ /төсөл/**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Корона вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор иргэн хуулийн этгээдээс санаачлан онцгой комиссын үйл ажиллагаанд сайн дурын үндсэн дээр хандивласан бэлэн мөнгө болон эд материалын хандивыг бүртгэж авах, зарцуулах, хяналт тавих, тайлагнахтай холбогдсон карилцааг зохицуулахад энэхүү журмыг баримтална.

1.2. Иргэн, хуулийн этгээдээс сайн дурын үндсэн дээр хандивлаж буй мөнгөн болон эд материалыг хандивын хөрөнгөнд тооцно.

Хоёр. Хандив хүлээн авах

2.1. Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн хандивын мөнгөн хөрөнгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт тоот дансанд төвлөрүүлнэ.

2.2 Хандивын мөнгөн хөрөнгийн бүртгэл тооцоог аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч хөтөлнө.

2.3 Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн хандивын эд зүйлсийг аймгийн Засаг даргын Тамгын газрын аж ахуйн ажилтан хүлээн авч данс бүртгэлд тусгаж, санхүүгийн баримт хөтөлнө.

Гурав. Хандивын зарцуулалт

3.1 Аймгийн онцгой комиссын шийдвэрээр хандивыг захиран зарцуулах бөгөөд, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга зарцуулалтад хяналт тавьж, аймгийн онцгой комиссыг мэдээллээр хангана.

3.2 Хандив болон түүний зарцуулалтын талаарх мэдээллийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч сар бүрийн эцэст шилэн дансанд тусгаж, олон нийтэд мэдээлэх бөгөөд Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга хяналт тавина.

Дөрөв. Тайлан гаргах

4.1 Хөрөнгийн зарцуулалтын тайланг аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч гаргаж, Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргаар хянуулна.

4.2 Эд зүйлийн зарцуулалтын тайланг эд хариуцсан аж ахуйн ажилтан буюу нярав хариуцан гаргана.

4.3 Дээрх тайланг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга хянан баталгаажуулж аймгийн онцгой комисст танилцуулан иргэд олон нийтэд мэдээлнэ.

Тав. Хэрэгжих хугацаа

5.1 Энэхүү журмыг батлагдсан өдрөөс дагаж мөрдөнө.